

2020 ОНД БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДЛЫН ТУХАЙ

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/121 дүгээр тушаалыг мөрдлөг болгон салбарын хэмжээнд цэргийн алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд гарсан офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, зохих шийдвэр гаргуулан, хуулийн хугацаанд нь хариуг өгч ажиллалаа.

Нэг. Батлан хамгаалах салбарын хэмжээнд өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар:

2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар иргэдээс 11967 өргөдөл, гомдол ирүүлснээс 11506 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хэрэгжилт 99,8 хувьтай байна. Өнөөгийн байдлаар шийдвэрлэхээр хүлээгдэж байгаа 15 өргөдөл байгаа бөгөөд холбогдох байгууллага, албан тушаалтанд харьяаллын дагуу 446 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шилжүүлсэн байна.

албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг нийт 5 сувгаар /иргэдийг хүлээн авах байранд биечлэн; 458929 дугаарын утсаар; Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс хуваарилагдаж ирсэн; шуудангаар; яамны цахим хуудас, олон нийтийн сүлжээ, албаны цахим хаягаар/ хүлээн авч, бүртгэл хөтлөлтийг хийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хүргүүлэн ажилласан болно.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авсан сувгуудаар нь ангилбал:

- ❖ 9975 буюу 87,0 хувь нь бичгээр;
- ❖ 1971 буюу 12,7 хувь нь биечлэн;
- ❖ 16 буюу 0,6 хувь нь ЗГ-ын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс;
- ❖ 14 буюу 0,13 хувь нь цахимаар;

Цэргийн алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагч, ажилтан 6 буюу 0,05 хувь нь утсаар тус тус ирүүлжээ.

Хоёр. Батлан хамгаалах яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар:

Батлан хамгаалах яамны удирдлагад хандаж иргэдээс 801 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 727 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, 69 өргөдлийг харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн өгсөн бөгөөд хэрэгжилт 99,2 хувьтай байна. 2020 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар 5 өргөдлийг судалж байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг албан тушаалтнуудад хандаж гаргаснаар нь харуулбал:

- | | |
|--|---------------------|
| ✓ Батлан хамгаалахын сайдад | 240 буюу 30 хувь; |
| ✓ Батлан хамгаалахын дэд сайдад | 84 буюу 10,5 хувь; |
| ✓ Төрийн нарийн бичгийн даргад | 241 буюу 30,1 хувь; |
| ✓ Төрийн захиргааны удирдлагын газрын даргад | 192 буюу 23,9 хувь; |

- ✓ Бусад газар, хэлтсийн дарга нарт 31 буюу 3,9 хувь;
- ✓ Албан тушаалын орон сууц хувьчлах болон хөнгөлөлттэй үнээр худалдан шилжүүлэх ажлын хэсэгт 13 буюу 1,6 хувь нь хаяглагдан ирсэн байна.

Гурав. Бусад байгууллагаас харьяаллын дагуу уламжлан ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар:

Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв байгууллага, Нутгийн өөрөө удирдах байгууллага болон яамны харьяа байгууллагуудаас 2020 онд нийт 116 өргөдөл, гомдол шилжин ирснийг судлан үзэж, хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээг авч, хариуг хугацаанд нь өгч ажиллалаа. Үүнд:

- Монгол Улсын Их Хурал 12 буюу 11,0 хувь;
- Ерөнхийлөгчийн Тамгын газар 7 буюу 6,1 хувь;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 8 буюу 7,0 хувь;
- Төрийн захиргааны төв байгууллага 2 буюу 1,7 хувь;
- Нутгийн өөрөө удирдах байгууллага 16 буюу 13,7 хувь;
- БХЯ-ны харьяа байгууллага 71 буюу 62,2 хувийг

тус тус эзэлж байгаа болно.

Батлан хамгаалах яам, харьяа байгууллагуудад ирүүлсэн өргөдлийг агуулгаар нь ангилбал дараах байдалтай байна. Үүнд:

- Нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэх хүсэлт 393 буюу 49,0 хувь;
- Гадаад, дотоодын цэргийн их, дээд сургуульд суралцах 165 буюу 20,5 хувь;
- Ажлын байртай холбоотой хүсэлт 205 буюу 25,5 хувь;
- Энхийг дэмжих ажиллагаанд оролцох хүсэлт 38 буюу 4,7 хувь зэрэг болно.

Дөрөв. Өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх хугацааг багасгах, ил тод, нээлттэй байдлыг хангах талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-д заасны дагуу иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг богино хугацаанд шийдвэрлүүлж, хуулийн хугацаанд нь хариуг өгөхөд анхаарал хандуулан ажиллаж байна.

Шийдвэрлүүлсэн хугацаагаар нь үзүүлбэл:

- ❖ 1-3 хоногт 331 буюу 41,3 хувь;
- ❖ 4-7 хоногт 270 буюу 33,7 хувь;
- ❖ 7-14 хоногт 107 буюу 13,3 хувь;
- ❖ 14-30 хоногт 93 буюу 11,6 хувь, хугацаа сунгагдаж шийдвэрлэгдсэн 7 өргөдөл байгаа нь 1,0 орчим хувийг эзэлж байгаа юм.

Иргэд, албан тушаалтнуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлын хариуг ихэвчлэн албан бичгээр, шаардлагатай тохиолдолд биечлэн амаар буюу харилцах утсаар аль болох түргэн шуурхай хүргэх хэлбэрийг сонгон ажиллаж байна.

Тав. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс хуваарилагдаж ирсэн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн талаар:

2020 онд Монгол Улсын Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс 7 хүсэлт, 6 гомдол, 3 талархал хуваарилагдан ирсэн байна. Тус төвөөс хуваарилагдаж ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг тухай бүрт нь хүлээн авч тодотгон, холбогдох арга хэмжээг авч, хариуг өгч ажилласан.

Мөн Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, мэдээлэл, танилцуулга бэлтгэн улирал, хагас жилээр тайланг гарган, тогтмол хүргүүлэн ажилласан болно.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн 2020 оны ... дугаар сарын ... -ны өдрийн ... дугаар хуралдааны тэмдэглэлд:

ТАНИЛЦСАН НЬ: “2020 онд Батлан хамгаалах салбарын хэмжээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдлын тухай”.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: “2020 онд Батлан хамгаалах салбарын хэмжээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдлын тухай” асуудалтай танилцаад дараах чиглэлийг яамны Төрийн захиргааны удирдлагын газарт даалгахаар тогтов” гэжээ. Үүнд:

- Батлан хамгаалах салбарт 2021 онд иргэдээс албан тушаалтнуудад хандан гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, хууль тогтоомжийг мөрдлөг болгон шийдвэрлүүлэхэд онцгойлон анхаарах, үр дүнг дээшлүүлэх;
- Зөвлөлийн гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийг цаашдын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх;
- Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлсэн талаарх тайлан мэдээг цаг хугацаанд нь гарган холбогдох байгууллагуудад тайлагнаж байх зэрэг болно.

ГАРЫН ҮСЭГ